

LEGAL NEWSLETTER

2024 September №49

AKP Law Firm

Бид энэ оны 9 дүгээр сард батлагдсан эсхүл хүчин төгөлдөр болсон хууль, Засгийн Газрын тогтоол, Сайдын тушаал зэргээс заримыг нь онцлон танилцуулж байна.

I. ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛСОН ХУУЛЬ

9 сарын 1 болж шинэ хичээлийн жил эхлэхтэй зэрэгцэн шинэчлэн найруулсан Хүүхэд хамгааллын тухай хууль хэрэгжиж эхлэв.

1.1. ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТУХАЙ ХУУЛЬ

§ Энэхүү хууль нь 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр батлагдсан ба ийнхүү 9 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хэрэгжиж эхлэв.

Тус хуулийн зорилго нь **хүүхэд хамгааллын үндэсний тогтолцоо, хүүхэд хамгаалалд оролцогч талуудын эрх, үүргийг тодорхойлох, хүүхдийг эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хүүхдэд шаардлагатай тусламж, үйлчилгээг үзүүлэх замаар хүүхдийн аюулгүй байдал, хүүхдийн хамгаалуулах эрх, хүүхдийн сайн сайхан байдлыг хангах** зэрэгт оршино.

§ Тус хуульд дурдсанаар хүүхэд хамгаалалд дараах зарчмуудыг баримтална. Үүнд: хүүхдийн эрх, дээд ашиг сонирхол, аюулгүй байдлыг нэн тэргүүнд тавих;

- ✓ хүүхдийн үзэл бодол, саналаа илэрхийлэх эрх, оролцоог хангах;
- ✓ хүүхэд хамгаалал нь тогтолцоонд суурилсан, гэр бүл төвтэй, олон талт, цогц, мэргэшсэн, дагнасан, шуурхай, хүртээмжтэй, үр дүнтэй байх;
- ✓ хүүхдийг гэр бүлээс нь тусгаарласан тохиолдолд нэн тэргүүнд төрөл, садны гэр бүлийн асрамжид байлгахыг эрмэлзэх, хүүхдийг ах, эгч, дүүтэй нь хамт байлгах;

- ✓ төр хүүхдийг хамгаалахдаа хүүхдийн аюулгүй, сайн сайхан байдлыг хангах зорилгод хүрэхэд зайлшгүй, тохирсон арга хэмжээ авах;
- ✓ хүүхдийн нөхцөл байдал, ялгаатай онцлогийг хүлээн зөвшөөрөх, хүүхдийн нэр төрийг хүндэтгэх.

Түүнчлэн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хүүхэдтэй шууд харьцаж ажилладаг болон бусад хүнд хүүхдийг хүмүүжүүлэх, хүүхэдтэй харилцахдаа бие махбодын шийтгэл хэрэглэх, гутаан доромжлохыг хориглоно.

II. ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 9 дүгээр сарын 11-ний өдөр Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 27.2 дугаар зүйлд заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас 75 дугаар тогтоолын хавсралтаар "Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх аргачлал"-ыг баталсан байна.

2.1. ТЭТГЭВРИЙН ХЭМЖЭЭГ НЭМЭГДҮҮЛЭХ АРГАЧЛАЛ

§ 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр баталсан энэхүү аргачлал нь Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 27.1 дүгээр зүйлд заасны дагуу тэтгэврийн хэмжээг өмнөх оны инфляцын жилийн дундаж түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэх ба дараах томьёотой байна.

$$T_i = T_{i-1} + T_{i-1} * (XY\Theta_{T_{i-1}} + (I_{i-2} - XY\Theta_{T_{i-2}}))$$

Энэхүү томьёонд байх хувьсагчуудыг дараах байдлаар тус тус тодорхойлно.

T_i :	Тухайн онд нэмэгдсэн тэтгэврийн хэмжээ;
T_{i-1} :	Өмнөх оны тэтгэврийн хэмжээ;
$XY\Theta_{T_{i-1}}$:	Монгол Улсын нэгдсэн төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөллийг баталсан хуулийн төсвийн хүрээний мэдэгдэлд заасан өмнөх оны хэрэглээний үнийн өсөлтийн түвшин;
$XY\Theta_{T_{i-2}}$:	Монгол Улсын нэгдсэн төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөллийг баталсан хуулийн

- төсвийн хүрээний мэдэгдэлд заасан 2 жилийн өмнөх хэрэглээний үнийн өсөлтийн түвшин;
- Ии-2: Үндэсний статистикийн хорооноос зарласан 2 жилийн өмнөх инфляцын жилийн дундаж түвшин;
- i: Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлж байгаа он.

Мөн тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх томьёоны (Ии-2-ХҮӨТi-2) үзүүлэлтийг 2025 онд тэг, 2026 оноос эхлэн өмнөх онд шинээр тэтгэвэр тогтоолгосон тэтгэвэр авагчдын хувьд тэг байхаар тус тус тооцох юм.

III. САЙДЫН ТУШААЛУУД

2024 оны 9 дүгээр сард Хууль зүй, дотоод хэргийн яамны сайд "Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид өмгөөлөгч томилж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулах журам" батлах тухай тушаал, Боловсролын сайд "Багшлах эрхийн гэрчилгээ олгох болон үүнтэй холбогдох үйл ажиллагааны журам"-ыг шинэчлэн батлах тушаал тус тус гаргажээ.

3.1. СЭЖИГТЭН, ЯЛЛАГДАГЧ, ШҮҮГДЭГЧИД ӨМГӨӨЛӨГЧ ТОМИЛЖ, ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦУУЛАХ ЖУРАМ

§ Хууль зүй, дотоод хэргийн яамны сайдын А/58 дугаартай тушаалын хавсралтаар батлагдсан энэхүү журмын дагуу сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, гэр бүлийн гишүүн, төрөл, садны хүн нь өмгөөлөгч сонгож авсан ч хүрэлцэн ирээгүй, эсхүл сонгон аваагүй тохиолдолд хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор Монголын Өмгөөлөгчдийн Холбооноос өмгөөлөгч томилж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулан сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалан өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцаа авах эрхийг хангана.

3.2. БАГШЛАХ ЭРХИЙН ГЭРЧИЛГЭЭ ОЛГОХ БОЛОН ҮҮНТЭЙ ХОЛБОГДОХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

§ Боловсролын сайдын А/64 дугаартай тушаалын хавсралтаар батлагдсан энэхүү журмаар багшийн мэргэжлээс бусад мэргэжилтэй иргэнд багшлах эрх олгох болон үүнтэй холбогдох үйл ажиллагааг зохицуулна.

§ Энэхүү журмын дагуу багшлах эрх авах хүсэлтэй иргэн нь багшлах эрх олгох сургалтад хамрагдах ба сургалт нь дараах төрлүүдтэй байна. Үүнд:

- 1) Багшаас бусад мэргэжлээр дээд боловсрол эзэмшсэн иргэнд багшлах эрх олгох сургалт;

- 2) Багш мэргэжил эзэмшсэн иргэнд боловсролын өөр түвшний боловсролын сургалтын байгууллагад, эсхүл өөр судлагдахууны чиглэлээр багшлах эрх олгох сургалт;
- 3) Багшаас бусад мэргэжлээр магадлан итгэмжлэгдсэн дээд боловсролын сургалтын байгууллагад суралцаж буй суралцагчдад багшлах эрх олгох сургалт.

§ Мөн дээрх сургалтад хамрагдахын тулд дараах шаардлагууд хангасан байна. Үүнд:

- 1) Математик болон байгалийн шинжлэх ухаан, анагаах ухаан, мэдээлэл харилцаа, технологи, хууль, бизнес, эдийн засаг, урлаг, англи хэлний чиглэлээр дээд боловсролын сургалтын байгууллагыг 2.7-оос доошгүй голч дүнтэй төгссөн, бакалавраас доошгүй зэрэгтэй байх, эсхүл эдгээр чиглэлээр магадлан итгэмжлэгдсэн дээд боловсролын сургалтын байгууллагад 2.7-оос доошгүй голч оноотой суралцаж байгаа гурав, дөрөвдүгээр ангийн суралцагч байх;
- 2) Эрүүгийн хуульд заасан авлига, албан тушаалын болон бусад гэмт хэрэг үйлдэж шүүхээр ял шийтгүүлж байгаагүй байх;
- 3) Монгол хэлний ярианы болон бичгийн чадвартай байх;
- 4) Сэтгэцийн өвчин, эмгэггүй байх.

§ Ийнхүү багшлах эрх олгох сургалтад хамрагдан багшлах эрхийн гэрчилгээ авсан иргэн нь сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын байгууллагатай Ажлын бүтэн бус цагаар ажиллуулах хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллана.

Дээрх агуулгатай холбоотой бусад дэлгэрэнгүй мэдээллийг авахыг хүсвэл доорх хаягаар холбогдоно уу.

ALISON & KATE PARTNERS

Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
3-р хороо, Жуулчны гудамж, Pearl tower А блок
902 тоот

Web: www.akp.mn

E-mail: contact@akp.mn

Tel: 7704-1414